



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит
Аудитын код: БНА-2019/26/СТА-ТШЗ



Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/64
танай _____-ны № _____-т

Г ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
З.ЦЭРЭНДОРЖ ТАНАА

Г Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жинст сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын

E:\Usukhuu\STA-2019\11.Жинст ЗДТГ\4.Тайлагнал\Жинст ЗДТГ_гэрчилгээ.docx

2519109

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга З.Цэрэндоржд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 24-нөөс 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Жинст сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Жинст сумын ЗДТГ нь “Төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэж сумын эдийн засгийн өсөлтийг тогтвортой хөгжүүлэн, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Жинст сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сахилга хариуцлага, ёс зүйг эрхэмлэн дээдэлж, ур чадвартай, зөв манлайлалтай байж ил тод, түргэн шуурхай, эелдэг харилцаатай, соёлтой үйлчилгээг ард иргэдэд үзүүлнэ.

Жинст сумын ЗДТГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Жинст сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Жинст сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Жинст сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Жинст сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Жинст сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 420770.1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 8415.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	6060.0	
	Дүн	3	6060.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал
Байхгүй

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Жинст сумын ЗДТГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 295046,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 293156,8 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь 2018 онд 295396,0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 2239,2 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Жинст сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс 20 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 гүйлгээг хугацаанд нь тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгдээгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Жинст сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНБООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Жинст сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 336.4 сая төгрөгийн зардлын гүйлгээ хийгдсэнээс түлш халаалтын зардлаас 1200.0 мянган төгрөгөөр байгууллагын ажилчдад нүүрс авч өгсөн байна.

Энэ нь “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн үрэлгэн зардал гаргахгүй байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

зөвшөөрсөн

3.2 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 8000,0 мянган төгрөг зарцуулсан ба үүнээс 4250,0 мянган төгрөгийн зардал нь засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамтай нийцээгүй байна.

Энэ нь “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" -ын 2.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам" -ыг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд олгосон цалингийн зардлын гүйлгээг цалингийн цэстээс давтан тооцоолж баталгаажуулахад зөрүү гараагүй болно. Харин цалингийн зардлаас татварын байцаагчийн урамшуулалд 430.0 мянга, байгууллагын шилдэг ажилтны шагналд 150.0 "Тэргүүний архивч" тэмдгийн дагалдах мөнгөн шагналд 30.0 мянган төгрөг тус зарцуулсан байна

Энэ нь “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Цалингийн зардлын тооцоог зөрүүтэй хийж, санхүүгийн тайланд буруу илэрхийлэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/Төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,771,200.00	11,037,950.00
33	АВЛАГА	00.00	3,400,000.00
335	Бусад авлага	00.00	3,400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,771,200.00	7,637,950.00
354	Хангамжийн материал	19,771,200.00	7,637,950.00
35420	Аж ахуйн материал	00.00	499,000.00
35440	Түлц, шатах тослох материал	261,250.00	00.00
35450	Барилгын засварын материал	3,753,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	15,756,950.00	7,138,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	847,223,036.73	862,576,264.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	847,223,036.73	862,576,264.67
392	Биет хөрөнгө	847,223,036.73	849,624,473.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,070,627,233.00	653,253,180.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-395,685,934.82	-45,042,516.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,870,760.00	125,170,760.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-61,422,801.24	-65,222,266.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,850,591.00	89,813,346.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-55,968,828.21	-64,328,313.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,072,331.91	54,023,331.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,359,302.49	-32,878,646.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	228,364,240.00	265,904,384.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-119,125,252.42	-131,068,786.13
393	Биет бус хөрөнгө	00.00	12,951,791.36
39301	Програм хангамж	1,550,000.00	3,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,550,000.00	-1,716,666.64
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	10,868,458.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	866,994,236.73	873,614,214.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	866,994,236.73	873,614,214.67
51	Засгийн газрын хувь оролцоо	866,994,236.73	873,614,214.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	378,800,666.00	382,993,124.00
51101	Өмч: - төрийн	378,800,666.00	382,993,124.00
512	Хуримтлагдсан үр дүн	147,223,178.73	121,088,068.88
51210	Өмнөх үеийн үр дүн	147,223,178.73	147,223,178.73
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-26,135,109.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	340,970,392.00	369,533,021.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	866,994,236.73	873,614,214.67

Жинст сумын ЗДТГ-ЫН-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	435,136,164.00	394,634,992.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,950,000.00	59,520,499.10
120	Нийтлэг татварын бус орлого	2,950,000.00	59,520,499.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,950,000.00	59,520,499.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,250,000.00	59,070,499.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,186,164.00	335,114,493.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	40,168,493.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	40,168,493.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,590,000.00	294,946,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,590,000.00	294,946,000.00
1330	Төсвийн захирагчдаас	103,596,164.00	00.00
133003	Хөрөнгийн	103,596,164.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	378,881,899.82	369,710,960.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	339,772,017.82	369,710,960.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	339,772,017.82	354,246,811.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,032,466.00	171,286,079.00
210101	Үндсэн цалин	181,032,466.00	171,286,079.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,847,651.00	20,179,719.00
210201	Тэтгэврийн даатгал	19,847,651.00	20,179,719.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,214,950.00	18,512,443.00
210301	Гэрэл, цахилгаан	2,327,110.00	2,447,453.00
210302	Тулш, халаалт	10,887,840.00	16,064,990.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,259,580.00	23,533,213.00
210401	Бичиг хэрэг	3,513,550.00	3,550,800.00
210402	Тээвэр, шатахуун	16,112,900.00	17,822,393.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,952,130.00	807,920.00
210404	Ном, хэвлэл	484,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	196,500.00	1,352,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,947,000.00	1,657,500.00
210604	Урсгал засвар	4,947,000.00	1,657,500.00
2107	Томилголт, зочны зардал	6,563,000.00	6,499,500.00
210702	Дотоод албан томилголт	6,563,000.00	6,499,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	950,901.00	36,509,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	425,100.00	36,509,240.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	47,400.00	00.00
210807	Газрын төлбөр	78,401.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,956,469.82	76,069,117.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,981,200.00	9,582,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	369,120.00	140,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,606,149.82	66,346,617.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,109,882.00	15,464,149.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	13,125,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	13,125,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,143,400.00	100,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,608,600.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,214,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,320,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,239,149.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,239,149.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,966,482.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,966,482.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,254,264.18	24,924,031.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	51,059,141.27
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	51,059,141.27
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-51,059,141.27
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,254,264.18	-26,135,109.85

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	329,440,000.00	335,564,493.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	850,000.00	450,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	850,000.00	450,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	850,000.00	450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	850,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	328,590,000.00	335,114,493.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	40,168,493.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	40,168,493.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	328,590,000.00	294,946,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,590,000.00	294,946,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	329,440,000.00	335,564,493.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,440,000.00	335,564,493.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,851,118.00	305,700,344.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,820,462.00	171,654,610.00
210101	Үндсэн цалин	167,087,756.00	150,864,137.00
210102	Нэмэгдэл	00.00	20,790,473.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,732,706.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,894,655.00	19,811,188.00
210201	Тэтгэврийн даатгал	23,894,655.00	18,003,726.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	451,315.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	362,854.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	91,464.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	901,829.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,476,200.00	18,251,193.00
210301	Гэрэл, цахилгаан	2,327,110.00	2,447,453.00
210302	Түлш, халаалт	11,149,090.00	15,803,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,612,900.00	28,655,113.00
210401	Бичиг хэрэг	3,826,170.00	3,442,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,403,600.00	17,822,393.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	2,787,130.00	915,920.00
210404	Ном, хэвлэл	399,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	195,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	196,500.00	6,278,500.00
2105	Нормативт зардал	62,500.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,480,000.00	7,257,500.00
210602	Тавилга	00.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	8,480,000.00	5,657,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,564,000.00	6,499,500.00
210702	Дотоод албан томилолт	6,564,000.00	6,499,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,780,901.00	44,375,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,552,500.00	44,298,740.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	77,000.00
210807	Газрын төлбөр	78,401.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,159,500.00	9,195,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,080,500.00	9,095,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	790,000.00	100,000.00

Жинст сумын ЗДТГ-ЫН-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,589,882.00	29,864,149.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	27,525,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	27,525,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,623,400.00	100,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,608,600.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,214,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	2,239,149.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,239,149.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,966,482.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,966,482.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	378,800,666.00	340,970,392.00	147,223,178.73	866,994,236.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	378,800,666.00	340,970,392.00	147,223,178.73	866,994,236.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	28,562,629.79	00.00	28,562,629.79
D08	Тайланг үеийн үр дүн	4,192,458.00	00.00	-26,135,109.85	-21,942,651.85
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	369,533,021.79	121,088,068.88	873,614,214.67

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	328,290,000.00	326,161,018.00	295,046,000.00	293,156,851.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,290,000.00	326,161,018.00	295,046,000.00	293,156,851.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,666,600.00	289,537,618.00	265,719,200.00	265,531,851.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,033,500.00	181,033,117.00	171,730,200.00	171,654,610.00
210101	Үндсэн цалин	170,105,300.00	170,104,917.00	135,455,400.00	150,864,137.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	36,274,800.00	20,790,473.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,928,200.00	10,928,200.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,606,500.00	20,606,500.00	19,855,300.00	19,811,188.00
210201	Тэтгэврийн даатгал	20,078,500.00	20,606,500.00	12,603,800.00	18,003,726.00
210202	Тэтгэмжийн даатгал	528,000.00	00.00	1,812,900.00	451,315.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,450,300.00	362,854.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	362,600.00	91,464.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	3,625,700.00	901,829.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,446,200.00	13,446,200.00	18,261,900.00	18,251,193.00
210301	Гэрэл, цахилгаан	2,694,900.00	2,694,900.00	3,045,300.00	2,447,453.00
210302	Түлш, халаалт	10,751,300.00	10,751,300.00	15,216,600.00	15,803,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,611,600.00	22,602,600.00	27,487,800.00	27,486,620.00
210401	Бичиг хэрэг	3,376,100.00	3,376,100.00	3,479,400.00	3,442,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,303,600.00	15,303,600.00	16,653,900.00	16,653,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,227,800.00	3,218,800.00	1,021,200.00	915,920.00
210404	Ном, хэвлэл	291,400.00	219,400.00	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	00.00	195,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	412,700.00	412,700.00	6,333,300.00	6,278,500.00

Жинст сумын ЗДТГ-ЫН-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,480,000.00	8,480,000.00	7,257,500.00	7,257,500.00
210602	Тавилга	00.00	00.00	1,600,000.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	8,480,000.00	8,480,000.00	5,657,500.00	5,657,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,563,000.00	6,563,000.00	6,550,800.00	6,499,500.00
210702	Дотоод албан томилолт	6,563,000.00	6,563,000.00	6,550,800.00	6,499,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,932,500.00	24,812,901.00	6,376,700.00	6,375,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,767,000.00	23,715,000.00	2,740,200.00	6,298,740.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	896,500.00	00.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,500.00	93,000.00	22,500.00	77,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00	50,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	3,564,000.00	00.00
210807	Газрын төлбөр	90,000.00	78,401.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11993300.00	11993300.00	8199000.00	8195500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,468,300.00	11,468,300.00	8,099,000.00	8,095,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	525,000.00	525,000.00	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36623400.00	36623400.00	29326800.00	27625000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	27,826,800.00	27,525,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	27,826,800.00	27,525,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,623,400.00	36,623,400.00	1,500,000.00	100,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,608,600.00	16,608,600.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,214,800.00	15,214,800.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	4,800,000.00	1,500,000.00	100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	328,290,000.00	326,161,018.00	295,046,000.00	293,156,851.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	327,690,000.00	325,623,518.00	294,446,000.00	292,706,851.00
132001	Орон нутгийн төсвөөс	327,690,000.00	325,623,518.00	294,446,000.00	292,706,851.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНА	600,000.00	537,500.00	600,000.00	450,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	600,000.00	450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	537,500.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	18.00	18.00